



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/81

Мөрөн сум

Биотехникийн арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.5.1, 6 дугаар зүйлийн 6.1.8, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын саналыг харгалзан өвөлжилт хүндэрч зэрлэг ан амьтан идэш тэжээлийн хомсдолд орж, үхэх тохиолдол гарсантай холбогдуулан Рашаант, Шинэ-Идэр сумдад зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авахад аймгийн Мал хамгаалах сангаас 100 боодол өвс олгосугай.

2. Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах өвсийг үнэ төлбөргүй хэлбэрээр аймгийн Мал хамгаалах сангаас олгохыг Мал хамгаалах сангийн менежер (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

3. Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авахад шаардлагатай хүн хүчээр дэмжлэг үзүүлж ажиллахыг Рашаант сумын Засаг дарга (Д.Амартүвшин), Шинэ-Идэр сумын Засаг дарга (М.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ажлыг тайлагнахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Мөнхжаргал)-д даалгасугай.

5. Биотехникийн арга хэмжээ авах амьтны тархац нутгийг оновчтой сонгож зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Мөнхжаргал), биотехникийн арга хэмжээнд зориулан тавьсан өвсийг мал идэхээс хамгаалах, зэрлэг ан амьтанд хүрч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Рашаант, Шинэ-Идэр сумдын Байгаль орчны мэргэжилтэн, Байгаль хамгаалагч нарт тус тус даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6717010362